



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАЛАНЖАРГАЛАН СУМ
“ЖОНШНЫ ХҮДЭР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСӨЛ**

**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5168449/

Хянасан:	БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч
Биелэлтийг тайлагнасан:	“Монголиан Флюр Спар” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Л.Энхбат/
	“Монголиан Флюр Спар” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн /Г.Нямбаяр/



АГУУЛГА

Агуулга	2
Зургийн жагсаалт.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	3
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн нэр, байршил.....	5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл	5
1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал.....	5
1.3.1. Баяжуулах үйлдвэр.....	6
1.3.2. Хаягдлын байгууламж	7
1.3.3. Дагалдах дэд бүтцийн байгууламжууд.....	8
1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал	9
1.5. Баяжуулах үйлдвэрийн технологийн дараалал.....	10
2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	11
2.1. Хөрсөн бүрхэвч.....	11
2.2. Агаарын чанар.....	11
2.3. Усан орчин	11
2.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг.....	11
3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	21
4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	22
4.3.1. Техникийн нөхөн сэргээлт.....	22
4.3.2. Зэрлэг амьтдад өвс тэжээл өгөх биотехникийн арга хэмжээ.....	23
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	26
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	28
4.6.1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ.....	30
4.6.2. Химийн бодисын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ.....	31
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	32
4.7.1. Ахуйн хог хаягдал	34
4.7.2. Аюултай хог хаягдал.....	36
4.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	38
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	40
4.9.1. Усны хяналт шинжилгээ	40
4.9.2. Хөрсний хяналт шинжилгээ	41
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн биелэлт.....	42
5. ДҮГНЭЛТ	43

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил.....	5
Зураг 2. Уурхайн дэд бүтцийн байршлыг харуулсан ерөнхий зураг.....	6
Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн харагдах байдал	7
Зураг 4. Хаягдлын далан харагдах байдал	7
Зураг 5. Үйлдвэрийг ЦЭХ-ээр хангах 35/0.4 кВ-ын дэд станц.....	8
Зураг 6. Усан хангамжийн хугдгуудийн харагдах байдал	9
Зураг 7. Ажилчдын оффис, гал тогоо, амрах байр харагдах байдал.....	9
Зураг 8. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем	10
Зураг 9. Замын тэмдэг тэмдэглэгээ.....	17
Зураг 10. Гүний худаг ба тоолуурын баталгаажилтын гэрчилгээ.....	17



Зураг 11. Усны төлбөр төлсөн баримтууд.....	18
Зураг 12. Усны тоолуурын заалтын баталгаажуулсан бичил.....	19
Зураг 13. Баяжуулах үйлдвэрийн ус ашиглалтын задаргаа.....	19
Зураг 14. Зогсоолын талбайг хайргаар хучсан байдал.....	20
Зураг 15. Засварын талбайг бетондсон байдал.....	20
Зураг 16. Асгаралтын иж бүрдэл.....	20
Зураг 17. Намрын мод тарилтын ажил гүйцэтгэж буй байдал.....	21
Зураг 18. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах тухай акт.....	22
Зураг 19. Цомог багт хийсэн нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгөх тухай албан бичиг.....	23
Зураг 20. Өвс худалдан авч, зэрлэг амьтдад тавьж өгөх арга хэмжээний төлбөр төлсөн баримт.....	23
Зураг 21. Өвс үйлдвэрийн хашаанаас ачиж сумын агуулахад хүлээлгэн өгч буй байдал.....	24
Зураг 22. Морин хуур хөгжмийн зэмсэг худалдан авах арга хэмжээнд туслалцаа үзүүлсэн тухай албан бичиг.....	26
Зураг 23. Даланжаргалан сумын соёлын төвд туслалцаа үзүүлсэн тухай албан бичиг.....	27
Зураг 24. Гал түймэр унтраах, аврах 023-р ангитай хамтарч нийт ажилчдад сургалт орж буй байдал.....	30
Зураг 25. Төслийн барилга байгууламжуудын галын аюулгүй байдлын дүгнэлт.....	30
Зураг 26. Химийн бодисын сургалт орж буй байдал.....	31
Зураг 27. Тайлант жилийн химийн бодисын ашиглалт, үлдэгдлийн тайлан.....	31
Зураг 28. Хог хаягдлын зориулалтын сав, хаягжуулалт.....	32
Зураг 29. Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулсан хог хаягдлын гэрээ.....	33
Зураг 30. Баяжуулах үйлдвэрийн орчимд цэвэрлэгээ хийж буй байдал.....	34
Зураг 31. Цэвэрлэгээгээр үүссэн хог хаягдлыг тээвэрлэж буй байдал.....	34
Зураг 32. Нийт ажилчдад хог хаягдлын сургалт орж буй байдал.....	35
Зураг 33. Хаягдал төмөр ачуулж буй байдал.....	35
Зураг 34. Ангилян ялгалтын хог хаягдлын сав, хог хаягдлын цэгийн харагдах байдал.....	35
Зураг 35. Хуванцар сав хүлээлгэн өгсөн тухай зарлагын баримт.....	36
Зураг 36. Аюултай хог хаягдлын бүртгэл.....	36
Зураг 37. Аюултай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээ.....	37
Зураг 38. Аюултай хог хаягдал ачуулж буй байдал.....	37
Зураг 39. Байгаль орчны аудитын тайлан, дүгнэлт.....	39
Зураг 40. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн хашаан дотор модны суулгац тариж буй байдал.....	39
Зураг 41. Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт бүхий шинжилгээний хариунууд.....	41
Зураг 42. Хөрсний дээжний шинжилгээний хариу.....	41

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Баяжуулалтын бүтээгдэхүүний баланс.....	9
Хүснэгт 2. 2023 оны БОМТ-ний биелэлт бүлэг тус бүрээр.....	14
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	16
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	21
Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	24
Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	25
Хүснэгт 7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	26
Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	28
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	33
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт.....	38
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт.....	40
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн хэрэгжилт.....	42



1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


“Монголианфлюорспар” ХХК нь Монгол улсад 2018 оноос хойш жилд бүрэн хүчин чадлаараа 40.0 мян.тн жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаагаа явуулж байгаа Монгол улсын 100%-ийн хөрөнгө оруулалттай үйлдвэр юм

Ордын дээжинд хийгдсэн баяжуулалтын технологийн шинжилгээгээр флюорит нь хүдэрт нарийн ба дунд зэргийн ширхэглэлээр /35-40%/ шигтгээлэгдсэн байхаас гадна энэ нь гранит-кварцын төрлийн эрдсүүдтэй нягт ургал үүсгэсэн байна гэж тодорхойлогдсон учир ордын хүдрийг баяжуулахын тулд 2 шатны бутлалт, нунтаглалт хийсний дараа флотацийн аргаар хүдрийг баяжуулан 32.75%-ийн гарцтай 97%-ийн агуулгатай жоншны баяжмал гарган авах боломжтой гэж үзсэн.



1.1. Төслийн нэр, байршил

Монголин Флюор Спар ХХК-ийн “Жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Монгол улсын урд хэсэгт, Дорноговь аймгийн “Даланжаргалан” сумын нутагт оршдог. Улаанбаатар хотоос урагш 290 км, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос хойш 149 км, Даланжаргалан сумаас зүүн хойд зүгт 1 км, Даланжаргалан сумаас Сайншанд чиглэлийн хатуу хучилттай замаас зүүн хойд зүгт 1 км зайд оршдог.




Зураг 1. Төслийн байршил

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр:	“Монголиан Флюор Спар” ХХК
Аж ахуйн нэгж бүртгэлийн дугаар:	000212212
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	Жонш худалдан авч, боловсруулан баяжуулах үйлдвэр
Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:	Улаанбаатар хот Баянгол, 4-р хороо, 2-р хороолол, 2, 8
Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Л.Энхбат, 88941111, mfsenkhat@gmail.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Байгаль орчны мэргэжилтэн Г.Нямбаяр, 80104089, nyambayar0525@gmail.com

1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Тус Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь 2015 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших 10 га талбайд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Монгол орны ихэнх ордуудын үйлдвэрлэлийн ач холбогдолтой жоншны хүдэр нь кварц-флюоритийн төрөлд хамрагддаг, ашигтай эрдэс нь CaF₂ байгаа ба флюоритийн багагүй агуулгатай, өнгөгүй, цөөн тохиолдолд ногоон ягаан өнгөтэй карбонатын маш бага агуулгатай, хорт хольц болох сульфид, фосфор бага байдаг учир өндөр чанарын баяжмал гарган авах боломжтой нь олон ордын хүдрийн шинж чанарын шинжилгээний дүнгээс харагдаж байна.



Зураг 2. Уурхайн дэд бүтцийн байршилг харуулсан ерөнхий зураг

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь хүдрийн агуулах талбай, хаягдлын далан, бутлах цех, төв корпус, баяжмал савлах, хадгалах хэсэг, дотоодын лаборатори, ажилчдын сууц, оффис байгууламж зэрэг дэд бүтэц болон дагалдах дэд бүтцийн байгууламжуудаас (үүнд угаалгын газар, ажилчдын байр, харуулын байр, усан болон цахилгаан хангамжийн байгууламжууд орно) бүрдэнэ.

1.3.1. Баяжуулах үйлдвэр

Баяжуулах үйлдвэр нь бутлах цех, төв корпус, шүүн хатаах цех, хаягдлын аж ахуй гэсэн цех хэсгүүдтэй байх бөгөөд энэ нь хоёр шатны бутлалт, нунтаглалт хийсний дараа хүдрээс флюоритын эрдсийг ялгах үндсэн ба хяналтын, цэвэрлэгээний флотацийн шат дамжлагуудаас бүрдэнэ. Үүнд:

- хүдэр хүлээн авах талбай
- хүдэр бутлах цех
- нунтаглан баяжуулах хэсэг
- баяжмал өтгөрүүлэх, шүүх хэсэг.
- баяжмалыг хатаах, савлах, хадгалах хэсэг
- хаягдлын болоод цэвэр усны цөөрөм, худаг зэрэг болно.



Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн харагдах байдал

1.3.2. Хаягдлын байгууламж

Баяжуулах үйлдвэрээс гарах нийт хаягдал нь жилд 6,409 тонн бүтээгдэхүүн, 15-20%-ийн ус хоёроос бүрдэнэ. Хаягдалд хортой хольц байхгүй.

Баяжуулах үйлдвэрээс гарсан технологийн хаягдлыг далангийн өндөрлөгөөнд ашиглахаар тусгасан. Далангийн нийт урт 120 м урт, өргөн 80 м, гүн нь 6 м, нийт эзэлхүүний хэмжээ 60 мян/м³ байна.

Хаягдлын сангийн байрлуулалт нь доорхи нөхцөл шаардлагыг хангасан. Үүнд:

- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх
- Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- Хаягдлыг эргүүлж ашиглах боломж бүрдсэн байх
- Хаягдлаас шүүрсэн ус гүний усанд нэвчихгүй байх нөхцөлийг хангах, нэвчилтийг хянах боломжтой байх
- Хаягдал тээвэрлэх зардал хямд байх
- Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх



Зураг 4. Хаягдлын далан харагдах байдал



1.3.3. Дагалдах дэд бүтцийн байгууламжууд

Баяжуулах үйлдвэрийн үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий дэд бүтцийн байгууламжуудад цахилгаан хангамжийн байгууламж, усан хангамжийн худгууд, ажилчдын оффис, амралтын байр, угаалгын газар зэрэг орно. Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн талбайд нийт 50 хүн хүлээн авах хүчин чадал бүхий ажилчдын амрах байр, гал тогоо, хооллох хэсэг, угаалгын газар, харуулын байр байх бөгөөд ажилчдын оффисод инженер техникийн ажилчид ажиллана.

Цахилгаан хангамж: Жоншны баяжуулах үйлдвэр нь GM1557 маркийн бөмбөлөгт тээрэм, PE250x400 маркийн хацарт бутлуур, PE100x600 маркийн хацарт бутлуур, GBQ50*965 чичиргээт шигшүүр, FG-5 маркийн мушгиа ангилуур, XJ-28 флотомашин, XJ-11 флотомашин, GW-2 маркийн вакуум филтр, NZS-3 маркийн өтгөрүүлэгч, насос зумпф, ВК–1000–20 i конвейер, ВК–650–30 i конвейер, ВК–500–10 i конвейер, ХВ-1500 контактын чан, тэжээгүүр, хатаах барабан зуух, насос /хаягдлын а/а/, кран /бутлах цех/, кран /флотацийн цех/ зэрэг цахилгаан хэрэглэгчидтэй байх бөгөөд тэдгээр хэрэглэгчид нь 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүч хэрэглэгч юм.

Тус үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт байрлалтай 35/10 кВ-ын Даланжаргалан дэд станцаас зүүн хойшоо 3 км зайд орших бөгөөд баяжуулах үйлдвэрийн тооцооны бүрэн цахилгаан ачаалал 746.41 кВА байгаа тул энэхүү чадлыг үндэслэн 800 кВА чадалтай S9-800 төрлийн 35/0.4 кВ-ын хүчний нэг трансформатортай трансформаторын дэд станцыг үйлдвэрийн дэргэд барьж байгуулсан. 35/10 кВ-ын Даланжаргалан дэд станцын шинэ өргөтгөлөөс АС-50 маркийн утастай төмөр бетонон тулгууртай өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барив. Үйлдвэрийн 35/0.4 кВ-ын дэд станцын 35 кВ талд нь 35 кВ-ын хуурай салгуур, цэнэг шавхагч тавьж, 0.4 кВ талд нь ерөнхий автомат, гаргалгааны тоогоор автоматтай 0.4 кВ-ын иж бүрэн хуваарилах байгууламжтай. 35/10 кВ-ын Даланжаргалан дэд станцын өргөтгөл, үйлдвэрийн 35/0.4 кВ-ын дэд станцуудад Монгол Улсын Стандарчилал хэмжил зүйн үндэсний төвөөс ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан өндөр нарийвчлал бүхий 3-н фазын /100 В-ын/ олон үйлдэлтэй электрон, 0.4 кВ импульсийн тоолууртай.



Зураг 5. Үйлдвэрийг ЦЭХ-ээр хангах 35/0.4 кВ-ын дэд станц

Усан хангамж: Баяжуулах үйлдвэр болон түүний дагалдах дэд бүтцүүдийн үйл ажиллагаанд ашиглах усны эх үүсвэрийг төслийн талбайд байрлах 4 ширхэг гүний худгаас татаж ашиглах бөгөөд нийлбэр ундарга нь 12 л/сек болно.



Зураг 6. Усан хангамжийн худгуудийн харагдах байдал



Зураг 7. Ажилчдын оффис, гал тогоо, амрах байр харагдах байдал

1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал

Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь 2015 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших 10 га талбайд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш баяжуулах үйлдвэр нь тогтмол тогтвортой үйл ажиллагаа явуулж ирсэн.

Технологийн схемийн тоо чанарын үзүүлэлтийн тооцоо нь технологийн процессын үйлдэл ба бүтээгдэхүүн тус бүрийн чанарын үзүүлэлтүүд болон тоон үзүүлэлтүүдийг тодорхойлдог. Бүтээгдэхүүний тоон үзүүлэлтэнд бүтээгдэхүүний гарц, хүдрийн хэмжээг тодорхойлох ба чанарын үзүүлэлтэнд бүтээгдэхүүн дэх металлын агуулгыг тодорхойлно. Баяжуулах үйлдвэрийн тухайн жилийн хүчин чадал 10.0 мян.тн 43.0 % CaF₂ дундаж агуулгатай хүдэр баяжуулж ФФ97%-ийн флюоритийн агуулгатай баяжмал гаргах юм.

Хүснэгт 1. Баяжуулалтын бүтээгдэхүүний баланс


№	Бүтээгдхүүний нэр	Бүтээгдэхүүн, тн/жил	Агуулга, %	Гарц, %	Эрдэс авалт, %
1	Баяжмал	3591	97.0	35.91	81.0
2	Хаягдал	6409	12.75	-	19.0
3	Анхдагч хүдэр	10.000	43.0	-	-



1.5. Баяжуулах үйлдвэрийн технологийн дараалал

Баяжуулах үйлдвэр нь бутлах цех, төв корпус, шүүн хатаах цех, хаягдлын аж ахуй гэсэн цех хэсгүүдтэй байх бөгөөд энэ нь хоёр шатны бутлалт, нунтаглалт хийсний дараа хүдрээс флюоритын эрдсийг ялгах үндсэн ба хяналтын, цэвэрлэгээний флотацийн шат дамжлагуудаас бүрдэнэ. Үүнд:

- хүдэр хүлээн авах талбай
- хүдэр бутлах цех
- нунтаглан баяжуулах хэсэг
- баяжмал өтгөрүүлэх, шүүх хэсэг.
- баяжмалыг хатаах, савлах, хадгалах хэсэг
- хаягдлын болоод цэвэр усны цөөрөм, худаг зэрэг болно.



Зураг 8. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем



2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслөөс байгаль орчны бүрдэл хэсгүүд болох газрын гадарга, хэвлий, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал зэрэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННУ-ний тодотгол тайланд нарийвчлан тусгаж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байдаг.

2.1. Хөрсөн бүрхэвч

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг товч дурдвал:

- Хөрс хуулалт, автотехникийн үйл ажиллагааны улмаас хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөх
- Ахуйн хог хаягдал ил задгай хаягдах, асгарах зэрэг болзошгүй сөрөг нөлөөллөөс үүдэн хөрсний бохирдол үүсэх.

2.2. Агаарын чанар

Төслийн талбай дахь хүдрийн овоолго, дэд бүтэц барилгын ажил, ил задгай хөрснөөс хийссэн тоос шороо нь орчны агаарыг бохирдуулах нэг эх үүсвэр болж болзошгүй. Мөн төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник, автомашинаас хийн хаягдал үүсэж болно.

Шинж чанар: Хуурайшилт ихтэй улиралд сул хөрс шороо салхинд хийсэж ойр орчны агаарыг тоосоор бохирдуулдаг. Тоос нь нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, ус үл нордгоос нордог хүртэлх хэмжээтэй хөрс, шорооны нийлмэл шинж чанартай байна.

Эх үүсвэр: Хүдрийн овоолго, эвдэрсэн газар, зам талбай. Хүдэр буулгах, тээвэрлэх, овоолго үүсгэх, баяжмал тээвэрлэх үед үүсэх тоос.

Тархалт: Төслийн талбай, үйл ажиллагаа явагдаж буй талбайн орчим.

Нөлөөлөлд өртөх зүйлс: Тоосжилт өндөртэй ажлын байранд байгаа хүмүүс.

2.3. Усан орчин

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд гадаргын усны эх үүсвэр ашиглахгүй бөгөөд төслийн талбайд байрлах 4 ширхэг гүний худгаас усны хэрэгцээг хангаж байна. Үүнээс үүдэн төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн нэг нь усны ундарга багасах, хомсдох юм.

Мөн төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь хаягдлын далангаас асгаралт үүсэж гүний усыг бохирдуулах явдал юм.

Үргэлжлэх хугацаа: Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд

Шинж чанар: Гүний усны хэт их хэрэглээ, хаягдлын далангаас хяналтгүй асгаралт үүсэх.

Эх үүсвэр: Гүний усны худгууд, хаягдлын далан.

Үргэлжлэх хугацаа: Энэхүү төлөвлөгөөний хамрах хүрээнд

Нөлөөлөлд өртөх зүйлс: Гадаргын болон гүний ус

2.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг

Барилгажилт, дэд бүтэц байгуулах үйл ажиллагаагаар хөрс хуулагдах талбайн ургамал нөмрөгт шууд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн үйл ажиллагаагаар үүсэх тоосжилт нь орчны ургамлын ургалт, өсөлт



хөгжилтөд болзошгүй сөрөг нөлөө учруулна. Төслийн ерөнхий үнэлгээгээр нэн ховор статус бүхий ургамал болон амьтан тодорхойлогдоогүй.

Шинж чанар: Төслөөс үүсэх дуу чимээнээс амьтад дайжих, хамгаалалтын хашаа барьснаар бэлчээрийн талбай хумигдах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Эх үүсвэр: Хөрс хуулалт, тээвэрлэлт, хашаа барих, барилгажилт

Үргэлжлэх хугацаа: Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд

Нөлөөлөлд өртөх зүйлс: Тухайн орчны хөрс, ургамал, амьтан



3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Монголиан Флюор Спар” ХХК нь “Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаа явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг гүйцэтгэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж мөн нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьсан.

Бид 2023 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлангийн судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

Төслийн 2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь хүдэр баяжуулалтын үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, барилга бүтээн байгуулалт зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Бид 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгож, төслийн үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн болно.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь төслийн талбай, түүнээс гадна ОХШХ-т багтсан хяналт шинжилгээний цэгүүд хамаарна.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Жонш баяжуулах үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 45 төсөвт болон төсөвт бус арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2023 оны 11-р сарын 01-ний өдрийн байдлаар БОМТ-ний биелэлт 98.6 хувьтай байна. Доорх хүснэгтэд 2023 оны БОМТ-ний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр тусгав. БОМТ-ний хэрэгжилттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллүүдийг уг тайлангийн холбогдох бүлгүүдээс харна уу.

Хүснэгт 2. 2023 оны БОМТ-ний биелэлт бүлэг тус бүрээр

№	БҮЛЭГ	БИЕЛЭЛТ
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	92%
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	100%
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	100%
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	100%
5	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	100%
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	95.4%
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	100%
9	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	100%
10	БОМТ-2022 хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	100%
11	2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	98.6



4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” түүний хавсралтад төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваан агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн энэхүү тайланг боловсрууллаа.

БОННУ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2023 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.

Тайлант онд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 10 арга хэмжээ төлөвлөснөөс 8 ажлыг хэрэгжүүлсэн буюу тогтмол хэрэгжиж байгаа. Үлдсэн 2 ажил хэрэгжиж эхэлсэн бөгөөд бүрэн дуусаагүй ажлууд болно. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 10-р сарын 31-ны өдрийн байдлаар 92%-тай байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажлуудын биелэлтийн тайлбарыг доорх хүснэгтээс, мөн нотлох баримтыг хавсралтаас харна уу.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Агаар			
1	100%	Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засах, услах	2023 оны 11-р сарын 1-ний өдрийн байдлаар зам талбайгаас үүсэх тоосжилтыг дарах зорилгоор нийт 27 м ³ ус ашигласан байна. Баяжуулах үйлдвэрийн дотоод зам нь 200 метр орчим урттай бөгөөд бид шаардлагатай тохиолдлуудад усалгааг хийж ажилласан. Мөн тайлант жилд зам талбайн усалгаанд ашигладаг гүний худгийн насос эвдэрснээс үүдэн усалгааг тогтмол гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн болно.
2	100%	Үйлдвэрийн орчны авто замд тэмдэгжүүлэлтийг нэмж байрлуулах	Баяжуулах үйлдвэрийн хашаа руу нэвтрэх цэг, дотоод авто замын эргэлтийн хэсгүүдэд шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байрлуулсан.
3	100%	Жонш боловсруулах үед ашиглах усны төлбөр тооцоог холбогдох байгууллагад төлөх	Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай 2023 оны 7-р сарын 24-ний өдөр байгуулсан 29 дугаар Ус ашиглах гэрээний 3.2.6-д заасны дагуу төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй 4 гүний худгийн тоолуурын бичилт сар бүрийн 25-ний өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Байгаль орчны мэргэжилтнийг байлцуулан акт үйлдэж ажилласан. Тайлант жилд 2023 оны 10-р сарын 23-ний өдрийн байдлаар 4 гүний худгаас нийт 1789.7 м ³ ус ашигласан байна.
4	100%	Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах	Ус ашиглах гэрээг Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай 2023 оны 7-р сарын 24-ний өдөр байгуулсан бөгөөд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Байгаль орчны мэргэжилтнийг байлцуулан сар бүр усны тоолуурын заалтыг баримтжуулж акт үйлдэж ажилласан.
5	70%	Жонш боловсруулалтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах	Зөвхөн шаардлагатай тохиолдолд усалгааг хийж байгаа бөгөөд цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлэн ашиглах боломжийг судлан ажиллаж байна.
6	100%	Хаягдлын сангийн аюулгүй байдлыг хангаж ажиллах	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс эхлэн 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 180 удаагийн үзлэгийг өдөр тутам хийсэн байна.
7	100%	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих, автозасвар болон автозогсоолын талбайг хайрган буюу бетонон хучилттай болгох	Холбогдох талбайнуудад хайрган хучилт хийсэн.
8	50%	Тээвэрлэлтийн олон салаа зам гарахаас сэргийлж дотоод, гадаад замын 2 талаар хязгаарлах далан тэмдэг тэмдэглэгээ хийх	Тэмдэг тэмдэглэгээг холбогдох газруудад байрлуулсан. Хязгаарлах далан байгуулах арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
9	100%	Байгаль орчинд үүсэж болзошгүй асгаралтын үед ашиглах, асгаралттай тэмцэх асгаралтын иж бүрдэл худалдан авч, шаардлагатай газруудад байршуулах	Нийт 2 асгаралттай тэмцэх иж бүрдэл худалдан авч, засварын талбай, химийн бодисын агуулахад байрлуулсан.
10	100%	Байгаль орчинд химийн бодисын асгаралтаас сэргийлж, химийн бодисын агуулахад үзлэг хийх	Тайлант жилд 7 хоног бүр химийн бодисын агуулахад үзлэг хийж ажилласан бөгөөд үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2023 оны 10-р сарын 31-ны байдлаар нийт 24 удаагийн үзлэг хийсэн байна.



Зураг 9. Замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 10. Гүний худаг ба тоолуурын баталгаажилтын гэрчилгээ

**“Монголиан Флюор Спар” ХХК-ийн “Жошины хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000574839607

Системийн огноо/System Date: 2023.10.28 16:35:00

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5009959450	МОНГОЛИАНФЛЮО Р СПАР	535,688.00 MNT	1.00
/ Таван зуун гучин таван мянга зургаан зуун наян найман төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number 100060000944	Нэр/Name До.Ус ашигласны төлбөр	535,688.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монголиан Флюор Спар 04.25-06.20 хүртэл Усны төлбөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000574846114

Системийн огноо/System Date: 2023.10.28 16:43:18

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5009959450	МОНГОЛИАНФЛЮО Р СПАР	422,331.00 MNT	1.00
/ Дөрвөн зуун хорин хоёр мянга гурван зуун гучин нэгэн төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number 100060000944	Нэр/Name До.Ус ашигласны төлбөр	422,331.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монголиан Флюор Спар 06.20-07.25 хүртэл Усны төлбөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000574848185

Системийн огноо/System Date: 2023.10.28 16:45:56

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5009959450	МОНГОЛИАНФЛЮО Р СПАР	821,334.00 MNT	1.00
/ Найман зуун хорин нэгэн мянга гурван зуун гучин дөрвөн төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number 100060000944	Нэр/Name До.Ус ашигласны төлбөр	821,334.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монголиан Флюор Спар 07.20-08.23 хүртэл Усны төлбөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000574850009

Системийн огноо/System Date: 2023.10.28 16:48:14

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5009959450	МОНГОЛИАНФЛЮО Р СПАР	269,821.00 MNT	1.00
/ Хоёр зуун жаран есөн мянга найман зуун хорин нэгэн төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number 100060000944	Нэр/Name До.Ус ашигласны төлбөр	269,821.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монголиан Флюор Спар 08.23-09.25 хүртэл Усны төлбөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000575581386

Системийн огноо/System Date: 2023.10.29 19:13:06

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5009959450	МОНГОЛИАНФЛЮО Р СПАР	191,481.00 MNT	1.00
/ Нэг зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун наян нэгэн төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number 100060000944	Нэр/Name До.Ус ашигласны төлбөр	191,481.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монголиан Флюор Спар 09.25-10.23 хүртэл Усны төлбөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000584474566

Системийн огноо/System Date: 2023.11.10 15:28:22

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5009959450	МОНГОЛИАНФЛЮО Р СПАР	484,528.00 MNT	1.00
/ Дөрвөн зуун наян дөрвөн мянга таван зуун хорин найман төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number 100060000944	Нэр/Name До.Ус ашигласны төлбөр	484,528.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Монголиан Флюор Спар 10.23-11.10 хүртэл Усны төлбөр


Зураг 11. Усны төлбөр төлсөн баримтууд


**“Монголиан Флюор Спар” ХХК-ийн “Жоинны хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

“МОНГОЛИАН ФЛЮОР СПАР” ХХК-ИЙН ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН
ЗААЛТЫН БАТАЛГААЖУУЛСАН БИЧИЛТ

Огноо: 2023 оны 06 сарын 20-ний өдөр

№	Эх үүсвэрийн төрөл	Зориулалт, худгийн дугаар	Өмнөх тоолуурын заалт м³ 04 сарын 25	Одоогийн тоолуурын заалт м³ 06 сарын 20	Тоолуурын гүйлт м³ 06 сарын 20
1	Гүний худаг	109°06'12.4" 45°55'56.0" мод услах, замын тоосжилт дарах, үйлдвэрийн технологийн хэрэглээнд (2209099984)	000.2 м³	27.2 м³	27.0 м³
2	Гүний худаг	109°06'07.1" 45°55'58.1" үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202001235)	847.4 м³	1072.8 м³	225.4 м³
3	Гүний худаг	109°06'05.1" 45°56'00.7" үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202001246)	1269.1 м³	1492.3 м³	223.2 м³
4	Гүний худаг	109°06'09.6" 45°56'00.2" уурын зуухны хэрэглээнд (2209099994)	000.2 м³	46.1 м³	45.9 м³
5	Эргэлтийн ус	1-р нуураас үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202304314)	000.4 м³	105.8 м³	105.4 м³


Баталгаажуулж бичилт хийсэн:
Дорноговь аймгийн Далангажаргалан сумыг төлөөлөн:
БОБМЭргэжилтэн:  С.Дандалбаатар


Баталгаажуулагч хүлээн зөвшөөрсөн:
“Монголиан Флюор Спар” ХХК-ийг төлөөлөн:
Дэд захирал:  Б.Боригл

“МОНГОЛИАН ФЛЮОР СПАР” ХХК-ИЙН ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН
ЗААЛТЫН БАТАЛГААЖУУЛСАН БИЧИЛТ

Огноо: 2023 оны 09 сарын 25-ний өдөр

№	Эх үүсвэрийн төрөл	Зориулалт, худгийн дугаар	Өмнөх тоолуурын заалт м³ 08 сарын 23	Одоогийн тоолуурын заалт м³ 09 сарын 25	Тоолуурын гүйлт м³ 09 сарын 25
1	Гүний худаг	109°06'12.4" 45°55'56.0" мод услах, замын тоосжилт дарах, үйлдвэрийн технологийн хэрэглээнд (2209099984)	27.2 м³	27.2 м³	0 м³
2	Гүний худаг	109°06'07.1" 45°55'58.1" үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202001235)	1538.6 м³	1700.2 м³	161.6 м³
3	Гүний худаг	109°06'05.1" 45°56'00.7" үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202001246)	2074.0 м³	2139.0 м³	65 м³
4	Гүний худаг	109°06'09.6" 45°56'00.2" уурын зуухны хэрэглээнд (2209099994)	107.8 м³	135.3 м³	27.5 м³
5	Эргэлтийн ус	1-р нуураас үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202304314)	7381.6 м³	11312.3 м³	3930.7 м³
6	Эргэлтийн ус	4-р нуураас үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202304381)	1472.7 м³	3009.9 м³	1537.2 м³


Баталгаажуулж бичилт хийсэн:
Дорноговь аймгийн Далангажаргалан сумыг төлөөлөн:
Татварын улсын байцаагч:  Б.Нямцэнэг

Баталгаажуулагч хүлээн зөвшөөрсөн:
“Монголиан Флюор Спар” ХХК-ийг төлөөлөн:
Дэд захирал:  Б.Боригл

Зураг 12. Усны тоолуурын заалтын баталгаажуулсан бичил

“МОНГОЛИАН ФЛЮОР СПАР” ХХК-ИЙН
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ АШИГЛАСАН УСНЫ ЗАДАРГАА

№	Эх үүсвэрийн төрөл	Зориулалт, худгийн дугаар	04.25-06.20						Нийт хэргэлсэн хэмжээ м³
			04.25-06.20	06.20-07.20	07.20-08.23	08.23-09.25	09.25-10.23	10.23-11.10	
1	Гүний худаг	109°06'12.4" 45°55'56.0" мод услах, замын тоосжилт дарах, үйлдвэрийн технологийн хэрэглээнд (2209099984)	27 м³	Насос шатсан	Насос шатсан	Насос шатсан	Насос шатсан	Насос шатсан	27 м³
2	Гүний худаг	109°06'07.1" 45°55'58.1" үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202001235)	225.4 м³	195.9 м³	269.9 м³	161.6 м³	159.6 м³	104.8 м³	1117.2 м³
3	Гүний худаг	109°06'05.1" 45°56'00.7" үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202001246)	223.2 м³	158.6 м³	423.1 м³	65 м³	0 м³	279.2 м³	1149.1 м³
4	Гүний худаг	109°06'09.6" 45°56'00.2" уурын зуухны хэрэглээнд (2209099994)	45.9 м³	46.9 м³	14.8 м³	27.5 м³	45.3 м³	24.1 м³	204.5 м³
5	Эргэлтийн ус	1-р нуураас үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202304314)	105.4 м³	4171.6 м³	3104.2 м³	3930.7 м³	3355 м³	1577.1 м³	16244 м³
6	Эргэлтийн ус	4-р нуураас үйлдвэрийн технологийн хэрэглээнд (202304381)	Насос солих	206.2 м³	1266.1 м³	1537.2 м³	50 м³	141.8 м³	3201.3 м³

Бүртгэл хөтөлсөн Ерөнхий нягтлан Н.Марал /  Огноо: 2023 оны 11 сарын 10-ний өдөр

Зураг 13. Баяжуулах үйлдвэрийн ус ашиглалтын задаргаа



Зураг 14. Зогсоолын талбайг хайргаар хучсан байдал



Зураг 15. Засварын талбайг бетондсон байдал



Зураг 16. Асгаралтын иж бүрдэл

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Монголиан Флор Спар ХХК нь байгаль орчинд хариуцлагатай байх, нөхөн сэргээлтийг Монгол улсын холбогдох хууль, эрх зүй, стандарт шаардлагуудад нийцүүлэхээс гадна тухайн бүс нутгийн цаг уурын онцлог, орчин нөхцөлд тохирсон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага арга зүйд тулгуурлан гүйцэтгэхийг зорин ажилладаг.

Тайлант жилд жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн шинээр газар хөндөөгүй тул нөхөн сэргээлт хийх шаардлага үүсээгүй болно. Төслийн 2023 оны БОМТ-ний хүрээнд баяжуулах үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар 100 хувьтай байна.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Баяжуулах үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн хашаанд дотор 100 ширхэг модны суулгац тарих	Монгол улсын MNS 6139:2010 стандартын 2.5-д заасны дагуу 11-р сарын 1-ний дотор намрын улиралд тарилтыг хийсэн. Модны суулгацуудыг төслийн хашаан дотор байрлах ажилчдын оффисын урд хэсгээр тарьсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум Мод үндэсний хөдөлгөөний хүрээнд, мөн баяжуулах үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ажилчдын амьдрах болон ажиллах орчныг сайжруулах зорилгоор тайлант жилд 100 ширхэг улиас модны суулгацыг тарьсан. Тухайн модны суулгацуудыг тарихдаа Монгол улсын MNS 6139:2010 стандарт заасны дагуу намрын тарилтыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 17. Намрын мод тарилтын ажил гүйцэтгэж буй байдал

4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монголиан Флюор Спар ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд бид 2023 онд биотехникийн арга хэмжээ болон дүйцүүлэн нөхөн сэргээлтийн арга хэмжээнүүдийг төлөвлөж байна. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох орон нутгийн Засаг даргын тамгын газартай хамтран эзэнгүй орхигдсон эвдэрсэн газрыг сонгон авч техникийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар 100 хувьтай байна.


4.3.1. Техникийн нөхөн сэргээлт

Бид Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад хүргүүлсэн албан хүсэлтийн дагуу тус сумын Засаг дарга 2023 оны 8-р сарын 7-ний өдрийн -1/339 тоот албан бичгээр Бичигт багийн Майхан дэл нэртэй эзэн холбогдогчгүй эвдрэл орж, орхигдсон газарт нөхөн сэргээлт хийлгэх саналыг хүргүүлсэн байдаг. Тус саналын хүрээнд бид 2023 онд тухайн газарт 0.78 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 2023 оны 9-р сарын 1-ний өдөр Даланжаргалан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байдаг /Хавсралт 1. Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн акт/.

ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ	
2023 оны 09дугаар сарын 01-ний өдөр	
1. Байршлын мэдээлэл	
1.1. Аймэг, нийслэлийн нэр	Дорноговь
1.2. Сум, дүүргийн нэр	Даланжаргалан
1.3. Газрын нэр	Майхан дэл
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл	
2.1. Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	Монголиан Флюор спар, 5168449
2.2. Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	АНН-н нөхөн сэргээлтийн сангаас
2.3. Тус газрын эвдрэлд өргсөн шалтгаан	Хууль бусаар жонш олборлосон
2.4. Тус талбайд нийт эвдрэлд өргсөн талбайн хэмжээ (га)	0,78
2.5. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийж мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, зөвшөөрлийн дугаар	үүгүй
3. 2023 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл	
Техникийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт
- Талбайн хэмжээ (0,78га)	- Талбайн хэмжээ (га)
- Зөрдлын хэмжээ (3,000,000)	- Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын зүйлийн нэр, ургамалжуулсан байдал
	- Зөрдлын хэмжээ ()
4. Орон зайн мэдээлэл	
4.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг	4.2. Хэмжилт, зураглал
	- Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр

Зураг 18. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах тухай акт

Мөн бид тайлант жилд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Цомог багийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Цомог багийн төвд байрлах 114.1 м² талбайд техникийн нөхөн сэргээлт хийж тухайн багийн Засаг даргад хүлээлгэн өгсөн байдаг.



Зураг 19. Цомог багт хийсэн нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгөх тухай албан бичиг

4.3.2. Зэрлэг амьтдад өвс тэжээл өгөх биотехникийн арга хэмжээ

Бид тайлант жилд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд зэрлэг амьтдад өвс тэжээл тавьж өгөх биотехникийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн. Тус арга хэмжээний хүрээнд 2023 оны 10-р сарын 13-ний өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад 01/211 тоот албан хүсэлт хүргүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд 100 боодол өвс худалдан авч зэрлэг амьтдад өгөх арга хэмжээний төлбөр болох 1,560,000 төгрөгийг холбогдох дансанд шилжүүлэн ажилласан.

Огноо/Date: 2023.11.05 13:17:04				
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information Журналын/Journal No: 11191478				
Системийн огноо/System Date: 2023.11.05 13:17:04				
Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5027492586	Н****Ж ОЮУНГЭРЭЛ	1,560,000.00 MNT	1.00
/ Нэг сая таван зуун жаран мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	-	Khun Bank - Хаан банк		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	1,560,000.00 MNT	1.00
	5363069554	П*****Н НЯМДАВАА		
Гүйлгээний утга/Transaction description: МФС 120 боодол өвсний үнэ				

Зураг 20. Өвс худалдан авч, зэрлэг амьтдад тавьж өгөх арга хэмжээний төлбөр төлсөн баримт



Зураг 21. Өвс үйлдвэрийн хашианаас ачиж сумын агуулахад хүлээлгэн өгч буй байдал

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Зэрлэг амьтдад өвс тэжээл өгөх биотехникийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх	Тус арга хэмжээний хүрээнд 2023 оны 10-р сарын 13-ний өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад 01/211 тоот албан хүсэлт хүргүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд 100 боодол өвс худалдан авч зэрлэг амьтдад өгөх арга хэмжээний төлбөр болох 1,560,000 төгрөгийг холбогдох дансанд шилжүүлэн ажилласан /Хавсралт 2. Өвс худалдан авах төлбөр төлсөн баримт/.
2	100%	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн удирдлагатай зөвшилцөн эзэнгүй орхигдсон эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Бид Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад хүргүүлсэн албан хүсэлтийн дагуу тус сумын Засаг дарга 2023 оны 8-р сарын 7-ний өдрийн -1/339 тоот албан бичгээр Бичигт багийн Майхан дэл нэртэй газарт нөхөн сэргээлт хийлгэх саналыг хүргүүлсэн. Тус саналын хүрээнд бид 2023 онд тухайн газарт 0.78 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 2023 оны 9-р сарын 1-ний өдөр Даланжаргалан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. /Хавсралт 1. Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн акт/.

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

БОМТ-нд тусгагдсаны дагуу 5463 га талбайд өвөлжөө, хаваржааны газар нь давхцалтай айл өрхүүдийн судалгаа 2018-2020 онд хийж “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн айлуудтай хамтран ажиллах гэрээ хийж, нөхөн олговрыг олгосон болно.

Үйлдвэрийн талбайгаас 5 км-ийн радиуст оршиж буй 13 айлтай нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг гэрээний дагуу 2017-2020 онуудад бүрэн хэрэгжүүлсэн. 2023 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Төлөвлөгдөөгүй	Бид өмнөх жилүүдэд нөлөөлөлд өртөгч орон нутгийн айл өрхүүдэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан тул 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл одоогоор олоогүй болно. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар 100 хувьтай байна.

Хүснэгт 7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй. Энэ тохиолдолд төрийн холбогдох байгууллагуудад мэдэгдэх бөгөөд тухайн олдворын бүрэн бүтэн байдлыг хангана	Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад археологийн болон палеонтологийн ховор түүхийн олдвор илрээгүй болно.
2	100%	Сум орон нутгийн хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор арга хэмжээ хэрэгжүүлэх хамтран ажиллах	Дорноговь аймгийн Даланжаргалан сумын соёлын төвийн даргын 2023 оны 9-р сарын 8-ний өдрийн 28 тоот албан хүсэлтийн дагуу соёлын төвийн заалны шалыг засварлах ажилд 1,500,000 төгрөгийн хандив үзүүлсэн. Мөн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 9-р сарын 15-ний өдрийн 32 тоот албан хүсэлтийн дагуу хүүхэд багачуудад соёлын өвийг уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд морин хуур хөгжмийн зэмсэг худалдан авах 600,000 төгрөгийн туслалцааг үзүүлж ажилласан /Хавсралт 3. Түүх соёлын өвийн хамгааллын арга хэмжээний хүрээнд үзүүлсэн хандив туслалцааны тухай баримтууд/.



Зураг 22. Морин хуур хөгжмийн зэмсэг худалдан авах арга хэмжээнд туслалцаа үзүүлсэн тухай албан бичиг



Зураг 23. Даланжаргалан сумын соёлын төвд туслалцаа үзүүлсэн тухай албан бичиг

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсруулсан.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан байгалийн гамшиг, гал түймэр зэрэг төслийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах, хариу арга хэмжээ авах арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төслийн 2023 оны БОМТ-ний Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар 100 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт болон хавсралт материалуудаас харна уу.

Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Галын аюулаас хамгаалах багаж хэрэгслийн иж бүрдлийг байрлуулах	Тайлант жилд 5 ширхэг галын хор шинээр худалдан авч шаардлагатай газруудад байрлуулсан. Мөн төслийн талбайд байсан хуучин галын хорнуудыг дахин цэнэглүүлж байрлуулан бэлэн байдлыг ханган ажилласан /Хавсралт 4. Галын хор худалдан авсан болон цэнэглэлт хийлгэсэн төлбөрийн баримт/.
2	100%	Галын дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар гаргуулах	Тайлант жилд 0000222, 0001846, 0000221 дугаартай Галын дүгнэлтүүдийг Дорноговь аймгийн Онцгой байдлын газраас авч хэрэгжилтийг ханган ажилласан /Хавсралт 5. Галын дүгнэлтүүд/.
3	100%	Химийн бодис, шатах тослох материалын асгаралтыг удирдах хэрэгслийг боломжит хэмжээгээр байрлуулах, хэрэглэх зааварчилгааг байршуулах	Химийн бодисын агуулах болон дотоод хэрэгцээний зөөврийн шатахуун түгээх станцад тус бүр 1 ширхэг асгаралттай тэмцэх иж бүрдэл худалдан авч байрлуулсан /Хавсралт 6. Асгаралттай тэмцэх иж бүрдэл байрлуулсан байдал/.
4	100%	"Галын аюулгүй байдал, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх" сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Галын аюулгүй байдал, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах тоног төхөөрөмж ашиглах сургалтыг Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах 023-р гал унтраах, аврах ангитай хамтран 2023 оны 5-р сард зохион байгуулж, нийт ажилчидад орсон /Хавсралт 7. Галын аюулгүй байдлын сургалтын бүртгэл/.
5	100%	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах, хамгаалах багаж хэрэгслийг ашиглах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтанд хамруулах	Химийн бодистой харьцан ажилладаг нийт 22 ажилчдад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх арга хэмжээний сургалтыг 2023 оны 6-р сард зохион байгуулсан /Хавсралт 8. Химийн бодистой харьцан ажилладаг ажилчдын сургалтын бүртгэл /.

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
6	100%	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад эрсдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах, хамгаалах багаж хэрэгслийг ашиглах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтанд хамруулах.	
7	100%	Ажлын байрны үзлэгээр химийн бодисын агуулахын агааржуулах системийн ажиллагаа, хоолойн бүрэн бүтэн байдал, суурины идэгдэлт, тавиурын холбоосны бүрэн бүтэн байдал, химийн бодисын сав баглаа боодолд хяналт тавих	Тайлант жилд Химийн бодисын агуулахад 7 хоног бүр үзлэг хийж ажилласан бөгөөд нийт 24 удаагийн үзлэгийг хийсэн байна /Хавсралт 9. Химийн бодисын агуулахад үзлэг хийсэн баримт/.
8	100%	Аюул тохиолдсон газрыг хамгаалалтанд авч, аюулын таних тэмдэглэгээг байршуулж холбогдох мэргэжлийн байгууллагыг дуудан туслалцаа авах	Тайлант жилд аюултай тохиолдол үүсээгүй болно.
9	100%	Химийн бодисын агуулахын хамгаалалтын хашаа, цоож, гэрэлтүүлгийг сайжруулах	2023 оны 4-р сард Химийн бодисын агуулахын цоож түгжээг шинээр сольж ажилласан.

4.6.1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Бид тайлант жилд галын аюулаас сэргийлэх, гал түймрийн аюул тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах гал түймэр унтраах, аврах 023-р ангитай хамтран галын аюулгүй байдал, гал унтраах багаж хэрэгсэл ашиглах сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан. Үүний хүрээнд тус гал түймэр унтраах, аврах ангийн 2 алба хаагч баяжуулах үйлдвэрийн төслийн талбайд хүрэлцэн ирж танхимын болон практик сургалт орсон.



Зураг 24. Гал түймэр унтраах, аврах 023-р ангитай хамтарч нийт ажилчдад сургалт орж буй байдал

Баяжуулах үйлдвэрийн төслийн талбайд байрлах жонш баяжуулах үйлдвэр, ажилчдын байрны галын дүгнэлтийг Дорноговь аймгийн Онцгой байдлын газраас 2021 оны 12-р сарын 14-ний өдөр авсан бөгөөд тус дүгнэлтүүд нь 2023 оны 12-р сарын 14-ний өдөр хүртэл хүчинтэй болно. Тайлант жилд дотоод хэрэгцээний зөөврийн шатахуун түгээх станцын галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2023 оны 4-р сарын 24-ний өдөр Дорноговь аймгийн Онцгой байдлын газраас авсан байдаг.



Зураг 25. Төслийн барилга байгууламжуудын галын аюулгүй байдлын дүгнэлт

4.6.2. Химийн бодисын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Химийн бодисын ашиглалтын үед үүсэж болох аливаа осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант жилд химийн бодистой харьцан ажилладаг ажилчдад холбогдох сургалтыг явуулсан. Тус сургалтын хүрээнд химийн бодисын аюулгүй ажиллагаа, химийн бодисоос үүдэн ажилтан осол эрсдэлд орсон тохиолдолд үзүүлэх анхны тусламж зэрэг сэдвээр нийт 22 ажилтанд сургалт орсон байна.



Зураг 26. Химийн бодисын сургалт орж буй байдал

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй нийт 10 төрлийн химийн бодисын хэрэглээг компанийн Ерөнхий нягтлан тогтмол тооллого хийж ажилладаг бөгөөд тайлант жилд нийт 26.7 тн химийн бодис ашигласан байна /Хавсралт 10. Тайлант жилийн химийн бодисын ашиглалт, үлдэгдлийн тайлан/.

"МОНГОЛИАН ФЛЮОР СПАР" ХХК-ийн ХИМИЙН БОДИСЫН 2023 ОНЫ АШИГЛАЛТ, ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН											
№	Монгол нэр	Олон улсын нэршил	Тэмбө	CAS дугаар	Зөвшөөрлийн дугаар, хүчингэй зугаа	Ашигласан он, тоо хэмжээ			Тайлант хамраах хугацаа		Агуулахад үлдсэн үлдэгдэл хэмжээ /кг/
						Хувиараар авсан хэмжээ /тн/	Хувиараар авсан хэмжээ /тн/	Ашигласан тоо	Он сар	Он сар	
1	Цууны хүчил	Acetic acid	CH ₃ COOH	64-19-7	№0001943 /2021.06.28-2024.12.31/	30	7.5	7	2023.01	2023.10	0.5
2	Борын хүчил	Orthoboric acid	H ₃ BO ₃	10043-35-3		10	2.5	2.3	2023.01	2023.10	0.2
3	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7674-01-0		30	7.1	6.3	2023.01	2023.10	0.8
4	Калийн гидроксид	Potassium hydroxide	KOH	1310-58-3		30	6	5	2023.01	2023.10	1
5	Эрихром	Eriochrome	C ₂₀ H ₁₂ N ₂ O ₂ Na	1787-61-7		0.2	0.2	0.05	2023.01	2023.10	0.15
6	Этилийн спирт	Ethanol absolute	C ₂ H ₆ O	64-17-5		6	2	1.5	2023.01	2023.10	0.5
7	Тимолфталейн	Thymolphthalein	C ₂₈ H ₃₀ O ₄	125-20-2		0.02	0.01	0.003	2023.01	2023.10	0.007
8	Флуорескон /кальцеин/	Calcein	C ₃₀ H ₂₆ O ₁₃ N ₂	154071-48-4		0.2	0.1	0.04	2023.01	2023.10	0.06
9	Трилон Б	Ethylenediamine tetraacetic acid disodium salt	C ₁₀ H ₁₂ N ₂ Na ₂ O ₆	6381-92-6		20	4	3	2023.01	2023.10	1
10	Хайлуурын хүчил	Hydrofluoric acid	HF	7664-39-3		20	2	1.5	2023.01	2023.10	0.5

Тайлан гаргасан:
"Монголиан флюор спар" ХХК-ийн Ерөнхий нягтлан Н.Марал /*Нарал*

Хянасан:
"Монголиан флюор спар" ХХК-ийн Үйлдвэрийн дарга Р.Энхбаяр /*Энхбаяр*

2023 оны 11 сар 01 өдөр

Зураг 27. Тайлант жилийн химийн бодисын ашиглалт, үлдэгдлийн тайлан

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Монголиан Флюор Спар ХХК нь БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд Жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллахыг зорьсон.

Монголиан Флюор Спар ХХК нь холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорин ажилладаг. Уг үйл ажиллагааны хүрээнд хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, дахивар хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг тусгайлан бэлдсэн агуулахад цуглуулж устгалд оруулах үйл ажиллагааг 2023 оны төлөвлөгөөнд оруулсан.

Бид холбогдох хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүний дагуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөл авсан Цэцүүх Трейд ХХК-д нийлүүлэн ажиллахаар 2023 оны төлөвлөгөөнд тусгаж оруулсан.


Тайлант жилд жонш баяжуулах үйлдвэрийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор баяжуулах үйлдвэрийн нийт талбайд байрлах хог хаягдлын савны тэмдэг, хаягжуулалтыг сайжруулах, нэгдсэн нэг загварт арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд хог хаягдлыг цаас, цаасан хаягдал, тосоор бохирдсон хаягдал, энгийн хаягдал, дахин боловсруулах хаягдал, аюултай хог хаягдал гэх мэт ангилсан.



Зураг 28. Хог хаягдлын зориулалтын сав, хаягжуулалт

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, ажилчдын кемпээс үүсэх ахуйн хог хаягдал зайлуулах үйлчилгээний гэрээг Даланжаргалан сумын Засаг даргатай 2022 оны 6-р сард байгуулсан. Тус гэрээний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүссэн энгийн хог хаягдлыг сар тутам Даланжаргалан суманд байрлах хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлж, гэрээнд заасан төлбөрийг тухай бүрд нь шилжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

**“Монголиан Флюор Спар” ХХК-ийн “Жошны хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**



Зураг 29. Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулсан хог хаягдлын гэрээ

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Хог хаягдлаа зориулалтын хогийн саванд цуглуулж, ангилан ялгаж хэвших, хог хадгалах түр цэгийг хаягжуулж хашаажуулах	Үйлдвэрээс гарч буй хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах зориулалтын сав хаягжуулан байрлуулж, нийт ажилчдад хог хаягдлын ангилан ялгалтыг хэвшүүлж ажилласан.
2	100%	Үйлдвэрийн талбай орчимд хог хаягдлын цэвэрлэгээ байнга хийх, эмх замбараагүй байдлыг цэгцлэх	Баяжуулах үйлдвэрийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг тогтмол хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	100%	Орон нутагтай хатуу хог хаягдлын гэрээ байгуулж, тогтоосон цэгт ахуйн хог хаягдлаа хүлээлгэн өгөх, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөх	Бид Даланжаргалан сумын Засаг даргатай 2023 оны 6-р сарын 3-ний өдөр Хог хаягдлын гэрээ байгуулсан. Тус гэрээний хүрээнд хог хаягдлын төлбөр сар бүр 500,000 төгрөг тушаахаар гэрээлсэн. Гэрээний хэрэгжилтийг ханган 2023 оны 6-р сарын 21-ний өдөр нийт 5 сарын төлбөр болох 2,500,000 төгрөгийг холбогдох дансанд шилжүүлсэн.
4	100%	Сум, олон нийтийг хамарсан их цэвэрлэгээ, үйл ажиллагаанд оролцох	Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12 заалт Аж ахуйн нэгж, байгууллага нь эргэн тойрны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх үүргийн дагуу баяжуулах үйлдвэрийн ойр орчмын цэвэрлэгээг бүрэн хийсэн. Тус цэвэрлэгээний хүрээнд үүссэн хог хаягдлыг 2 удаа тээвэрлэлт хийн сумын төвлөрсөн хог хаягдлын цэгт нийлүүлсэн.
5	100%	Бусад дахивар хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах холбогдох үйлдвэрийг судалж нийлүүлэх /Хаягдал дугуй, картон цаас/	Тайлант жилд хаягдал дугуй, картон цаас зэрэг дахин боловсруулах хог хаягдал бага хэмжээтэй үүссэн бөгөөд хангалттай хэмжээнд үүсэж, цугларсны дараа дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
6	100%	Ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг олгох, дадал зуршлыг хэвшүүлэх;	Бид тайлант жилд нийт 3 удаагийн сургалтаар 38 ажилтанд хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулсан.
7	100%	Уурхайн талбайд шинээр ажиллахаар ирж буй бүх ажилчдад хог хаягдлын сургалт орох	
8	100%	Уурхайн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих	Хог хаягдлын савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тайлант жилд үүсээгүй болно. Тэмдэг, тэмдэглэгээ муудсан тохиолдолд үүссэн тохиолдолд тухай бүрд нь сольж, шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
9	50%	Дахивар хүлээн авагчийг судлах, хаягдлын ангилал тус бүрээр нийлүүлэх	Тайлант жилд үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан төмрийн хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.
10	100%	Засвар үйлчилгээнээс гарсан /төмөр, бусад/ хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	
11	100%	Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэх, мэдээллэх	Аюултай хог хаягдал үүссэн тохиолдол бүрт бүртгэл хөтлөн ажиллаж байна.

4.7.1. Ахуйн хог хаягдал

Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу баяжуулах үйлдвэр, түүний ойр орчимд хаягдсан ахуйн хог хаягдлыг цэвэрлэх, түүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд нийт 2 машин ахуйн хог хаягдал үүссэн бөгөөд үүнийг Даланжаргалан сумын төвлөрсөн хог хаягдлын цэгт нийлүүлэн ажилласан.



Зураг 30. Баяжуулах үйлдвэрийн орчимд цэвэрлэгээ хийж буй байдал




Зураг 31. Цэвэрлэгээгээр үүссэн хог хаягдлыг тээвэрлэж буй байдал

Нийт ажилчдын хог хаягдлын менежментийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ангилан ялгалтыг сайжруулах зорилгоор 4 удаагийн давтамжтайгаар 38 ажилтанд сургалт зохион байгуулсан.



Зураг 32. Нийт ажилчдад хог хаягдлын сургалт орж буй байдал

Тайлант жилд баяжуулах үйлдвэрийн засвар, үйлчилгээний арга хэмжээнээс үүссэн төмрийн хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.



Зураг 33. Хаягдал төмөр ачуулж буй байдал

Баяжуулах үйлдвэрийн талбайн шаардлагатай байрлалуудад хог хаягдлын ангилан ялгалтын сав байрлуулсан бөгөөд төслийн талбайд байрлах хог хаягдлын түр цэгийг хашаажуулж, хог хаягдал хийсэх, задгай талбайд тархахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.



Зураг 34. Ангилан ялгалтын хог хаягдлын сав, хог хаягдлын цэгийн харагдах байдал

**“Монголиан Флор Спар” ХХК-ийн “Жохины хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Бид тайлант жилд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн нийт 50 кг хуванцар савны хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

ЗАРЛАГЫН БАРИМТ №

Монголиан Флор Спар (байгууллагын нэр) Р.Шиндэр (худалдагчагийн нэр)
 Регистрийн № [] Регистрийн № []
 2023 оны 9 сарын 11 өдөр (тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмжээ нэгж	Худалдах		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Хуванцар		10кг		10000	
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
Дүн						

Тэмдэг: Хүлээлгэн өгсөн эд хариуцагч: [Хуванцар] / Хүлээн авагч: [Хуванцар] / Шалгасан нягтлан бодогч: [Хуванцар]

ЗАРЛАГЫН БАРИМТ №

Монголиан Флор Спар (байгууллагын нэр) Р.Шиндэр (худалдагчагийн нэр)
 Регистрийн № [] Регистрийн № []
 2023 оны 10 сарын 12 өдөр (тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмжээ нэгж	Худалдах		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Хуванцар		10кг		10000	
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
Дүн						

Тэмдэг: Хүлээлгэн өгсөн эд хариуцагч: [Хуванцар] / Хүлээн авагч: [Хуванцар] / Шалгасан нягтлан бодогч: [Хуванцар]

Зураг 35. Хуванцар сав хүлээлгэн өгсөн тухай зарлагын баримт

4.7.2. Аюултай хог хаягдал

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал үүсэх тохиолдол бүрт холбогдох бүртгэлийг хөтлөн ажиллаж байна.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ТООЛӨГЫН ХҮСНЭГТ

Улаан бүртгэлийн дугаар: 901120100
 Регистрийн дугаар: 216449
 Аюултай хог хаягдал тусгагчийн дугаар: 001155
 Урьдчилалгүйгээр чиглэл: Баяжуулах үйлдвэр

№	Аюултай хог хаягдлын нэр (МОНГОЛ БОРИ)	Нийлэмж хэмжээ (кг, тн, ш)	Самуулагч (хүний, бичиг, нийл, бичиг)	Төрөл	Нийлэмж хэмжээ (кг, тн, ш, тн)	Бодлогын төрөл (хүний, бичиг, нийл, бичиг)	Хаягдлын бүр нийлэл				
							Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал	
1	Хуванцар сав	10кг	Хуванцар	Хуванцар	10кг	Хуванцар					
2	Хуванцар сав	10кг	Хуванцар	Хуванцар	10кг	Хуванцар					
3	Хуванцар сав	10кг	Хуванцар	Хуванцар	10кг	Хуванцар					
4											
5											
6											
7											
8											
9											
10											

Томьлоо хийгвэ: [Хуванцар] / [Хуванцар] / [Хуванцар]

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ТООЛӨГЫН ХҮСНЭГТ


Улаан бүртгэлийн дугаар: 901120100
 Регистрийн дугаар: 216449
 Аюултай хог хаягдал тусгагчийн дугаар: 001155
 Урьдчилалгүйгээр чиглэл: Баяжуулах үйлдвэр

№	Аюултай хог хаягдлын нэр	Нийлэмж хэмжээ (кг, тн, ш)	Самуулагч (хүний, бичиг, нийл, бичиг)	Төрөл	Нийлэмж хэмжээ (кг, тн, ш, тн)	Бодлогын төрөл (хүний, бичиг, нийл, бичиг)	Хаягдлын бүр нийлэл				
							Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал	
1	Хуванцар сав	10кг	Хуванцар	Хуванцар	10кг	Хуванцар					
2	Хуванцар сав	10кг	Хуванцар	Хуванцар	10кг	Хуванцар					
3	Хуванцар сав	10кг	Хуванцар	Хуванцар	10кг	Хуванцар					
4											
5											
6											
7											
8											
9											
10											

Томьлоо хийгвэ: [Хуванцар] / [Хуванцар] / [Хуванцар]

Зураг 36. Аюултай хог хаягдлын бүртгэл

Бид Аюултай хог хаягдлын тээвэрлэлтийн гэрээг холбогдох тусгай зөвшөөрөл бүхий Цэцүүх Трейд ХХК-тай 2023 оны 3-р сарын 1-ний өдөр байгуулсан.



Зураг 37. Аюултай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээ

Тайлант жилд 1 удаа аюултай хог хаягдал тээвэрлэлт хийсэн. Тус арга хэмжээний хүрээнд 200 литр багтаамжтай төмөр пошик 102 ширхэг, Хуванцар канистр 33 ширхэг, химийн бодисын сав баглаа боодол 1350.1 кг тээвэрлэн Цэцүүх Трейд ХХК-д хүлээлгэн өгсөн байна /Хавсралт 11. Аюултай хог хаягдлын дагалдах бичиг/.



Зураг 38. Аюултай хог хаягдал ачуулж буй байдал


4.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Энэхүү төлөвлөгөөний хүрээнд бид баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаан дахь байгаль орчны арга хэмжээг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах	Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах гал түймэр унтраах, аврах 023-р ангитай хамтран холбогдох сургалтын зохион байгуулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Осол эрсдлийн менежментийн бүлгээс харна уу.
2	100%	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг үйлдвэрийн бүсэд байрлуулах	Нийт ажилчдад хог хаягдлын менежмент, ангилан ялгалтын сургалтыг орсон. Дэлгэрэнгүй мэдээллийг Хог хаягдлын менежментийн бүлгээс харна уу.
3	-	Аймгийн Засаг даргаар тээврийн замын маршрутыг тогтоолгох	Тайлант жилд Дорноговь аймгийн Засаг даргад 2023.04.04, 2023.04.25, 2023.07.03, 2023.10.13 өдрүүдэд тээврийн замын маршрут тогтоолгох тухай хүсэлтийг хүргүүлсэн. 2023 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар бидэнд албан тоотой маршрут батлах тухай хариу хүргүүлээгүй байна.
4	100%	БОрчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэн зөвлөмжийн биелэлтийг Аймгийн БОГ-т хүргүүлэх,	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг Эко Нэйшнл ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
5	100%	Экологийн паспорт хөтлөх	Холбогдох хууль, дүрэм, журмын шаардлагын дагуу экологийн паспортыг хөтөлж ажиллаж байна.
6	100%	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн хашаан дотор модны суулгац тарих	Тус хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн хашаан дотор нийт 100 ширхэг модлог ургамлын суулгацыг тарих арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр заалтад заасны дагуу Байгаль орчны аудитыг Эко Нэйшнл ХХК-тай гэрээ байгуулан 2023 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2023 оны 8-р сарын 31-ний өдрийн хооронд баяжуулах үйлдвэрийн талбайд зохион байгуулсан. Тус аудитын хүрээнд нийт 100 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн бөгөөд 83 шалгуур бүрэн биелсэн, 11 шалгуур бүрэн бус, 6 шалгуур биелээгүй буюу 83 хувь биелэлттэй дүгнэлт гарсан. Тус аудитын дүгнэлтийг бид Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023 оны 9-р сарын 28-ний өдөр албан тоотын хамт хүргүүлсэн. Аудитын хүрээнд бидэнд хүргүүлсэн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээнүүдийг 2024 оны БОМТ-д тусган оруулж, хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна.



Зураг 39. Байгаль орчны аудитын тайлан, дүгнэлт



Зураг 40. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн хашаан дотор модны суулгац тариж буй байдал

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго нь тухайн төслийг хэрэгжүүлэх нутгийн байгаль орчин, нутгийн оршин суугчдад тухайн төслийн хэрэгжилтийн улмаас үзүүлэх нөлөөллийг хянах, тэдгээрийг бууруулах оновчтой арга хэмжээг сонгох, уг сонгосон арга хэмжээнүүд үр дүнгээ өгч буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн засаг захиргаа, хяналт тавих эрх бүхий байгууллагууд болон нутгийн оршин суугчдыг бодитой мэдээллээр хангахад оршино.

Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, тэдгээрийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал болон холбогдон гарах зардлуудыг урьдчилан тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулсан.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч Монголиан Флюор Спар ХХК нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүн, тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.



Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар 2 цэгт нийт 2 удаа гүйцэтгэх, үр дүнг боловсруулах	Агаарын чанарын хэмжилт улирал бүр тогтмол хийгдэж байна.
2	100%	Хөрсний дээжлэлтийг хяналтын цэгт 2 удаа гүйцэтгэж, Монгол улсад магадлан итгэмжлэгдсэн лабораторид харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх	Хөрсний дээжлэлт шинжилгээний ажлыг улиралд 1 удаа гүйцэтгэж байна.
3	100%	Гүний усны худаг болон хаягдлын далангаас улиралд 1 удаа дээжлэлт гүйцэтгэж харгалзах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлж үр дүнг нэгтгэн боловсруулах	Гүний усны дээжлэлт, шинжилгээний ажил улирал бүр хийгдэж байна.

4.9.1. Усны хяналт шинжилгээ

Тайлант жилд гүний усны худаг болон хаягдлын далан, бохир уснаас нийт 2 удаагийн дээжлэлт хийж Монгол улсад магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн ажиллалаа. Тус шинжилгээнүүдийн хариунаас харахад гүний худгуудын Хуурай үлдэгдэл, Цахилгаан дамжуулах чанар холбогдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлтүүд гарсан байна. Энэ нь тухайн худгууд тогтмол байнгын ашиглалт бага байдгаас үүдэн тундасжилт үүссэн эсвэл дээжлэлтийг бид буруу хийснээс үүдэн тунадас үүсэн байж болзошгүй гэж үзэж байна. Иймд 2024 оны ОХШХ-ийн хүрээнд дээжлэлтийн арга хэмжээнд байгаль орчны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, магадлан итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлж ажиллахаар төлөвлөж байна.

**“Монголиан Флюор Спар” ХХК-ийн “Жоинны хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**


 ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ /Central inspection laboratory/		 ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС /Test result of accredited laboratory/	
Захиалагчийн нэр / Customer name /: “Монголиан Флюор Спар” ХХК		Дээжний хэлт, байршил /Sample location/	
Шинжилгээний төлөрмөлт /Analysis type/	Дээжний дугаар /Test number/	Дээжний хэлт, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/
Цэвэр усны хими	№ 461	Дорноговь аймаг, Далайнгаргаан сум, Цомог баг	Гүний худаг
Дээжний хэмжээ /Quantity of sample/	Дээж хүлээн авсан өгнөө /Receiving date/	Шинжилсэн өгнөө /Analyzing date/	Хэвлэсэн өгнөө /Printed date/
1.5л/ 1.5l	2023.04.21	2023.04.21-05.08	2023.05.10
		Хэвлэсэн өгнөө /Printed date/	Техникийн шаардлага /Technical requirements/
			MNS 0900:2018

№	Үзүүлэлт /Parameters/	Шинжилэх аргын стандарт /Test method/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үр дүн /Test result/
1	pH Усны орчин /Hydrogen ions/	MNS ISO 10523-2001	6.5-8.5	7.08
2	Шингэлтэн дамжуулах чанар, мСм/см /Electrical conductivity/	MNS ISO 7888-1999	<1.0	3.00
3	Ерөнхий хатуулаг, мг-экв/л /Total hardness, mg-eq/L/	MNS ISO 6059-2005	<7.0	9.20
4	Кальци, (Ca ²⁺) мкг/л /Calcium ion, mg/L/	MNS 1097-1970	<100.0	88.18
5	Магни, (Mg ²⁺) мкг/л /Magnesium ion, mg/L/	MNS 1097-1970	<30.0	88.37
6	Карбонат, (CO ₃) мкг/л /Carbonate ion, mg/L/	MNS ISO 9963-1-2005	-	0.00
7	Хлорид, (Cl ⁻) мкг/л /Chloride ion, mg/L/	MNS ISO 9297-2005	<350.0	538.84
8	Гидрокарбонат, (HCO ₃ ⁻) мкг/л /Hydrocarbon ion, mg/L/	MNS ISO 9963-1-2005	-	268.40
9	Нитрат, (NO ₃ ⁻) мкг/л /Nitrate ion, mg/L/	MNS 4431-2005	<1.0	0.28
10	Нитрат, (NO ₂ ⁻) мкг/л /Nitrite ion, mg/L/	MNS ISO 7890-3-2001	<50.0	12.40
11	Төмөр, (Fe ³⁺) мкг/л /Iron ion, mg/L/	MNS 4430-2005	<0.3	0.04
12	Сулфат, (SO ₄ ²⁻) мкг/л /Sulfate ion, mg/L/	MNS 6271-2011	<500.0	452.95
13	Хуурай үндэс, мкг/л /TDS, mg/L/	MNS 4423-1997	<1000.0	1678.54
14	Натри + Кали, (Na ⁺ K ⁺) /Sodium+Potassium ion, mg/L/	MNS 1097-1970	<200	460.80
15	Аммон, (NH ₄ ⁺) мкг/л /Ammonia ion, mg/L/	MNS 1097-1970	<1.5	0.61

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/ Ө.Энхбаярагалан /Ekhbayaragalan, U/

Хянасан /Approved/ Хими /Chemist/ Н.Халиунаа /Khalunaa, N/

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/ Д.Мөнхтүл /Munkhtul, D MSc/ Хувьцаа /page: 1/3

 ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ /Central inspection laboratory/		 ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС /Test result of accredited laboratory/	
Захиалагчийн нэр / Customer name /: “Монголиан Флюор Спар” ХХК		Дээжний хэлт, байршил /Sample location/	
Шинжилгээний төлөрмөлт /Analysis type/	Дээжний дугаар /Test number/	Дээжний хэлт, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/
Цэвэр усны хими	№ 468	Дорноговь аймаг, Далайнгаргаан сум, Цомог баг, Байгуулах үйлдвэрийн гүний худагын ус	Гүний худаг
Дээжний хэмжээ /Quantity of sample/	Дээж хүлээн авсан өгнөө /Receiving date/	Шинжилсэн өгнөө /Analyzing date/	Хэвлэсэн өгнөө /Printed date/
5.0л/ 5.0l	2023.04.24	2023.04.24-05.08	2023.05.10
		Хэвлэсэн өгнөө /Printed date/	Техникийн шаардлага /Technical requirements/
			MNS 0900:2018

№	Үзүүлэлт /Parameters/	Шинжилэх аргын стандарт /Test method/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үр дүн /Test result/
1	pH Усны орчин /Hydrogen ions/	MNS ISO 10523-2001	6.5-8.5	7.80
2	Шингэлтэн дамжуулах чанар, мСм/см /Electrical conductivity/	MNS ISO 7888-1999	<1.0	2.98
3	Ерөнхий хатуулаг, мг-экв/л /Total hardness, mg-eq/L/	MNS ISO 6059-2005	<7.0	8.40
4	Кальци, (Ca ²⁺) мкг/л /Calcium ion, mg/L/	MNS 1097-1970	<100.0	72.14
5	Магни, (Mg ²⁺) мкг/л /Magnesium ion, mg/L/	MNS 1097-1970	<30.0	68.37
6	Карбонат, (CO ₃) мкг/л /Carbonate ion, mg/L/	MNS ISO 9963-1-2005	-	0.00
7	Хлорид, (Cl ⁻) мкг/л /Chloride ion, mg/L/	MNS ISO 9297-2005	<350.0	553.02
8	Гидрокарбонат, (HCO ₃ ⁻) мкг/л /Hydrocarbon ion, mg/L/	MNS ISO 9963-1-2005	-	292.80
9	Нитрат, (NO ₃ ⁻) мкг/л /Nitrate ion, mg/L/	MNS 4431-2005	<1.0	0.00
10	Нитрат, (NO ₂ ⁻) мкг/л /Nitrite ion, mg/L/	MNS ISO 7890-3-2001	<50.0	17.20
11	Төмөр, (Fe ³⁺) мкг/л /Iron ion, mg/L/	MNS 4430-2005	<0.3	0.11
12	Сулфат, (SO ₄ ²⁻) мкг/л /Sulfate ion, mg/L/	MNS 6271-2011	<500.0	437.76
13	Хуурай үндэс, мкг/л /TDS, mg/L/	MNS 4423-1997	<1000.0	1598.00
14	Натри + Кали, (Na ⁺ K ⁺) /Sodium+Potassium ion, mg/L/	MNS 1097-1970	<200	492.10
15	Аммон, (NH ₄ ⁺) мкг/л /Ammonia ion, mg/L/	MNS 1097-1970	<1.5	0.26

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/ Ө.Энхбаярагалан /Ekhbayaragalan, U/

Хянасан /Approved/ Хими /Chemist/ Н.Халиунаа /Khalunaa, N/



Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/ Д.Мөнхтүл /Munkhtul, D MSc/ Хувьцаа /page: 1/3

Зураг 41. Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт бүхий шинжилгээний хариунууд

4.9.2. Хөрсний хяналт шинжилгээ

Тайлант жилд нийт 15 ширхэг хөрсний дээж авсан бөгөөд магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн үр дүнд боловруулалт хийсэн. Тус шинжилгээний хариунуудаас харахад тайлант жилд холбогдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй болно.

 “ДЭЭЖ” ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН		 “ДЭЭЖ” ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	
Дээжний бүртгэлийн дугаар: 2318-811407 Захиалагч: “Байгаль, Орчин Судалгаа Шинжилгээний Газар” Дээж авсан цэг: Дорноговь аймаг, Далайнгаргаан сум, Хөгийн цэг, “Монголианфлюор спар” ХХК Газарын байршил: 109-0608”, 49-5602” Дээжний дугаар: S-6 Холбоо барих дугаар: 99090728		Дээжний бүртгэлийн дугаар: 2317-1948 Захиалагч: “Байгаль, Орчин Судалгаа Шинжилгээний Газар” Дээж авсан цэг: Дорноговь аймаг, Далайнгаргаан сум, Ковч “Монголиан флюор спар” ХХК Дээжний дугаар: S-1 Холбоо барих дугаар: 99090728	
Дээжний дугаар S-611407	Дээжний нэр Хөрс	Хуурай үндэс 2023.05.08	Шинжилсэн өгнөө 2023.06.12
Хөрсний зургууд бүхий шинжилгээний дүн, 1тр хэргэмд			
Дээжний дугаар S-611407	Нэмэлт тус MNS 6341-2012	Гадаргын савлагаа/DMT TSP (E Саг) MNS 3307-2004	Аналитик (C) референс MNS 6341-2012
Шинжилгээний хариу 4.6*10 ⁴	Шинжилгээний хариу 0.001	Бодиллын хариу 3	Бодилгын хариу 0.01
Жин: Энэүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжний сорьдод хэмжээг ба тухайн олшруулалтыг хэргэмд.			
Сорилтыг гүйцэтгэсэн Шинжээч А.Номин, M.Sc		Хянаж баталгаажуулсан Лабораторийн эрхлэгч Д.Золзаяа, M.Sc	

 “ДЭЭЖ” ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН		 “ДЭЭЖ” ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	
Дээжний бүртгэлийн дугаар: 2317-1948 Захиалагч: “Байгаль, Орчин Судалгаа Шинжилгээний Газар” Дээж авсан цэг: Дорноговь аймаг, Далайнгаргаан сум, Ковч “Монголиан флюор спар” ХХК Дээжний дугаар: S-1 Холбоо барих дугаар: 99090728		Дээжний бүртгэлийн дугаар: 2317-1948 Захиалагч: “Байгаль, Орчин Судалгаа Шинжилгээний Газар” Дээж авсан цэг: Дорноговь аймаг, Далайнгаргаан сум, Ковч “Монголиан флюор спар” ХХК Дээжний дугаар: S-1 Холбоо барих дугаар: 99090728	
Дээжний дугаар 7-31948	Дээжний нэр Хөрс	Хуурай үндэс 2023.07.03	Шинжилсэн өгнөө 2023.07.21
I. Хөрсний механик бүрэлдэлт			
Дээжний дугаар 7-31948	Шинжилгээний аргын стандарт MNS 6824-2020	Дээж авсан гүн, см 0-30	Механик сорьтууд, % ширхэгийн хэмжээ, мм 1: 0.25 0.25-0.05 0.05-0.01 0.01-0.005 0.005-0.001 >0.001 <0.01
II. Хөрсний химийн үндэс, үзүүлэлтүүд			
Дээжний дугаар 7-31948	Шинжилгээний аргын стандарт MNS 3310-1991	Дээж авсан гүн, см 0-30	Сорилтын сууринд, мг/кг/100г pH 7.48 Давс % 0.53 ЦЦН, dsm % 0.427 Ялгам % 7 СаСО ₃ % 3 Мр ²⁺ 3 РүО ₂ 6 К ₂ О 41
Жин: Энэүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжний сорьдод хэмжээг ба тухайн олшруулалтыг хэргэмд.			
Сорилтыг гүйцэтгэсэн Шинжээч Г.Сүдэмсэ		Хянаж баталгаажуулсан Лабораторийн эрхлэгч Д.Золзаяа, M.Sc	

Зураг 42. Хөрсний дээжний шинжилгээний хариу

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн биелэлт

Монголиан Флюор Спар ХХК нь аймаг, сум, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд болон төслийн ойр орчимд байрлах орон нутгийн айл, өрхтэй нээлттэй харилцаатай байж, үнэн бодит мэдээллээр хангах, хамтран ажиллах зарчмыг баримтлан ажиллахыг зорьдог. Үүний хүрээнд бид тайлант жилд доорх ажлуудыг БОМТ-д тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн хэрэгжилт

№	Хэрэгжилт	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	100%	Багийн ИНХ-д Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах, хэлэлцүүлэх	Даланжаргалан сумын Цомог багийн ИНХ-д хуралд оролцох хүсэлтийг бид 2023 оны 10-р сарын 30-ний өдөр тус багийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд ИНХ-д 2023 оны 11-р сарын 5-ний өдөр оролцож компанийн үйл ажиллагаа, БОМТ-ний хэрэгжилт, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний танилцуулгыг хүргүүлсэн /Хавсралт 12. Багийн ИНХ-д оролцох тухай албан хүсэлт/.
2	100%	Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт БОМТ-ний биелэлтийн тайланг холбогдох журамд заасан хугацааны дотор хүргүүлэх	БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу БОМТ-ний биелэлтийн тайланг 11-р сарын 1-ний дотор БОАЖГ-т хүргүүлэх ёстой байдаг. Бид тайлант жилд компанийн дотоод үйл ажиллагаа, төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс биелэлтын тайланг хугацаанаас хоцорч хүргүүлж байна.

5. ДҮГНЭЛТ

Монголиан Флюор Спар ХХК нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн холбогдох заалтууд болон 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа

Төслийн 2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь хүдэр баяжуулалтын үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, барилга бүтээн байгуулалт зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг товч байдлаар нэгтгэн дүгнэвэл:

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дүгээр заалтад заасны дагуу Байгаль орчны аудитыг Эко Нэйшнал ХХК-тай гэрээ байгуулан 2023 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2023 оны 8-р сарын 31-ний өдрийн хооронд баяжуулах үйлдвэрийн талбайд зохион байгуулсан. Тус аудитын хүрээнд нийт 100 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн бөгөөд 83 шалгуур бүрэн биелсэн, 11 шалгуур бүрэн бус, 6 шалгуур биелээгүй буюу 83 хувь биелэлттэй дүгнэлт гарсан.
- Монгол улсын MNS 619:2010 стандартын 2.5-д заасны дагуу 11-р сарын 1-ний дотор намрын улиралд тарилтыг хийсэн. Модны суулгацуудыг төслийн хашаан дотор байрлах ажилчдын оффисын урд хэсгээр тарьсан.
- Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай 2023 оны 7-р сарын 24-ний өдөр байгуулсан 29 дугаар Ус ашиглах гэрээний 3.2.6-д заасны дагуу төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй 4 гүний худгийн тоолуурын бичилт сар бүрийн 25-ний өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Байгаль орчны мэргэжилтнийг байлцуулан акт үйлдэж ажилласан. Тайлант жилд 2023 оны 10-р сарын 23-ний өдрийн байдлаар 4 гүний худгаас нийт 1789.7 м³ ус ашигласан байна.
- Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг дарга хүргүүлсэн албан хүсэлтийн дагуу тус сумын Засаг дарга 2023 оны 8-р сарын 7-ний өдрийн -1/339 тоот албан бичгээр Бичигт багийн Майхан дэл нэртэй эзэн холбогдогчгүй эвдрэл орж, орхигдсон газарт нөхөн сэргээлт хийлгэх саналыг хүргүүлсэн байдаг. Тус саналын хүрээнд бид 2023 онд тухайн газарт 0.78 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 2023 оны 9-р сарын 1-ний өдөр Даланжаргалан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байдаг.
- Бид тайлант жилд галын аюулаас сэргийлэх, гал түймрийн аюул тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах гал түймэр унтраах, аврах 023-р ангитай хамтран галын аюулгүй байдал, гал унтраах багаж хэрэгсэл ашиглах сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан. Үүний хүрээнд тус гал түймэр унтраах, аврах ангийн 2 алба хаагч баяжуулах үйлдвэрийн төслийн талбайд хүрэлцэн ирж танхимын болон практик сургалт орсон.
- Химийн бодисын ашиглалтын үед үүсэж болох аливаа осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант жилд химийн бодистой харьцан ажилладаг ажилчдад холбогдох сургалтыг орсон. Тус сургалтын хүрээнд химийн бодисын аюулгүй ажиллагаа, химийн бодисоос үүдэн ажилтан осол эрсдэлд орсон тохиолдолд үзүүлэх анхны тусламж зэрэг сэдвээр нийт 22 ажилтанд сургалт орсон байна.

- Баяжуулах үйлдвэрийн талбайн шаардлагатай байрлалуудад хог хаягдлын ангиалан ялгалтын сав байрлуулсан бөгөөд төслийн талбайд байрлах хог хаягдлын түр цэгийг хашаажуулж, хог хаягдал хийсэх, задгай талбайд тархахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Бид тайлант жилд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн нийт 50 кг хуванцар савны хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- Тайлант жилд 1 удаа аюултай хог хаягдал тээвэрлэлт хийсэн. Тус арга хэмжээний хүрээнд 200 литр багтаамжтай төмөр пошик 102 ширхэг, Хуванцар канистр 33 ширхэг, химийн бодисын сав баглаа боодол 1350.1 кг тээвэрлэн Цэцүүх Трейд ХХК-д хүлээлгэн өгсөн байна.
- Даланжаргалан сумын Цомог багийн ИНХ-д хуралд оролцох хүсэлтийг бид 2023 оны 10-р сарын 30-ний өдөр тус багийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд ИНХ-д 2023 оны 11-р сарын 5-ний өдөр оролцож компанийн үйл ажиллагаа, БОМТ-ний хэрэгжилт, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний танилцуулгыг хүргүүлсэн

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд компанийн удирдлагаас эхлээд гүйцэтгэх түвшний бүх ажилчид, сум орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, малчдын бүлэг түүний гишүүдийн оролцоотойгоор амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.